



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 11/2022

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 03/02 дугаар тогтоолын 2.4.1.6, 2.4.1.7 дахь заалт, 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” 03/03 дугаар тогтоолын 2.4.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Бруцеллэз өвчнөөс үхэр сүргийг эрүүл болгон баталгаажуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай


2. Бруцеллэз өвчнөөс эрүүлийг баталгаажуулах ажлын мэдээллийг малчдад хүргэн, үхэр сүргийг бэлэн байлгах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон хугацаанд арга хэмжээнд үхэр сүргээ бүрэн хамруулахыг мал бүхий иргэд, малчдад тус тус үүрэг болгосугай.

3. Тандалтад хамрагдах өрх, малын тоо, дээж авах маршрут, зураглал, хүн хүч, зардлын судалгааг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө аймгийн Мал эмнэлэгийн газарт хүргүүлэхийг (П.Аюушжав), (Р.Даваасүрэн) нарт даалгасугай.

4. Уг ажилд шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Санхүү албаны дарга (О.Отгонтуяа)-д даалгасугай.

5. Ажлын тайланг 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Мал эмнэлэгийн газар хүргүүлэн ажиллахыг (П.Аюушжав), (Р.Даваасүрэн) нарт үүрэг, болгосугай.


ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

622202265

Бат-Өлзий сумын Засаг даргын 2022
оны 3 дугаар сарын 31 өдрийн 4/129
тоот захирамжийн 1 дүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

- Гишүүд:
- П.Аюушжав (Мал эмнэлэгийн улсын байцаагч)
 - Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)
 - Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
 - С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
 - Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)
 - Л.Балжинням (5 дугаар багийн Засаг дарга)
 - Д.Дэмиддавга (6 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Р.Даваасүрэн (Тархвар зүйч)

---o0o---

Бат-Өлзий сумын Засаг даргын
2022 оны 08 сарын 31-ны өдрий А/129 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ТАНДАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ
БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Өвт

№	Хэрэгжүүлэх ажил үйлчилгээ	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэгч
1	Сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан, удирдамж, төлөвлөгөө боловсруулах	9-р сарын 01-нээс өмнө	П.Аюушжав	ЗДТГ
2	Тандалтад хамрагдах өрх, малын тоо, дээж авах маршрут, зураглал, хүн хүч, зардлын нарийвчилсан судалгаа гаргах	9-р сарын 01-ны дотор	Р.Даваасүрэн	Багийн Засаг дарга нар
3	Төслийн танилцуулга, ХАА-н зохистой дадал эзэмшүүлэх гарын авлага, малаас хүнд дамжин халдварладаг бруцеллөз өвчний гарын авлага, бэлтгэж хэвлүүлэх	9-р сарын 5-ны дотор	Р.Даваасүрэн	Мал эмнэлгийн лаборатори
4	Тандалт судалгааны явцад хөтлөх дээжийн бүртгэлийг гаргах	9-р сарын 5-ны дотор	Р.Даваасүрэн	Мал эмнэлгийн лаборатори
5	Тандалтанд хэрэглэгдэх зарим хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, хүнсний зардлыг тооцон Малын тоо, толгойн албан татварын Мал хамгаалах сангаас шийдүүлэх	9-р сарын 1-нээс өмнө	П.Аюушжав Р.Даваасүрэн	ЗДТГ
6	Тандалтын зураглал гаргах/ ARCGIS программ дээр/	Тандалтын явцад	Р.Даваасүрэн	Мал эмнэлгийн газар
7	Шинжилгээний хариуг малчдад 14 хоногийн дотор МЭТасаг, МЭҮНэгж, цахим болон утсан холбоогоор эргэн мэдээлнэ	9-р сарын 15-ны дотор	П.Аюушжав Р.Даваасүрэн	Мал эмнэлгийн лаборатори
8	Сургууль, цэцэрлэгт тендэрээр сүү нийлүүлдэг аж ахуй нэгж, малчин өрхийн үнээнээс сүүний дээж цуглуулан, сүүний цагирган урвалын шинжилгээг хийх	Тандалтын хугацаанд	Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн лаборатори	Мал эмнэлгийн лаборатори, Багийн Засаг дарга нар, Малчид
9	1,2,3,4,5,6 дугаар багийн бүх монгол үнээний сүүний дээжинд /СЦУ/-аар тандалт шинжилгээ хийх, эерэг гарсан өрхийн бүх үхрээс цусны дээж авч /РБУ, ХХУ, ЭЛИЗА/-гаар баталгаажуулж, эцсийн дүнг УМЭАЦТЛабораторид баталгаажуулах	9-р сарын 15-ны дотор	МЭТасаг, Мал эмнэлгийн лаборатори	БЗД нар, Малчид
10	Сүүний цагирган урвалаар “эерэг” гарсан өрхийн малчдад ХАА-н зохистой дадал нэвтрүүлэх сургалт зохион байгуулсан байна	Тандалтын хугацаанд	МЭТасаг, МЭ-ийн лаборатори	БЗД нар, Малчид

11	1,2,3,4,5,6 дугаар багийн сүүний шинжилгээнд хамрагдаж эерэг гарсан өрхийн бүх үхрийг ээмэгжүүлэн бүртгэх	9-р сарын 15-ны дотор	МЭТасаг, Мал эмнэлгийн лаборатори	БЗД нар Малчид
12	2021 онд хийгдсэн бруцеллөз өвчний тандалт шинжилгээгээр малд нь бруцеллөз өвчин оношлогдсон 4 багийн 22 өрхийн малчин мал бүхий иргэдэд Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран сургалт зохион байгуулах хүний бруцеллөзын халдварын талаарх тайлан гаргах	9-р сарын 20	ЗДТГ, сумын ЭМТ	МЭТасаг
13	Ажлын тайланг тайлагнах	9-р сарын 25	П.Аюушжав Р.Даваасүрэн	Мал эмнэлгийн газар

Бат-Өлзий сумын Засаг даргын
2022 оны 08 сарын 31-ны өдрийн А/129 тоот
захирамжийн 3 дугаар хавсралт

БРУЦЕЛЛЭЗ ӨВЧНӨӨС ҮХЭР СҮРГИЙГ ЭРҮҮЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХАД
ШААРДЛАГАТАЙ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Ажиллах хоног	Ажиллах хүн хүч	Төслөөс	МЭГазраас	МЭТасгаас	Нийт
1	7	Ажиллах хүн хүч	3	8	2	13

Хөдөлмөр хамгаалал, бичгийн хэрэгсэл

№	Зардлын нэр төрөл	Хэмжээ	Шаардлагатай тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бээлий/ажлын/	ш	400	2000	800000
2	Хурууны лент/нарийн/	Хайрцаг	10	2000	20000
3	Хурууны лент/бүдүүн/	хайрцаг	10	4500	45000
4	Шилний харандаа	ш	20	2000	40000
Бүгд:					905000

Шатахууны зардал

№	Төрөл	км	л	1л үнэ	Нийт дүн
1	1-р баг сүүний дээж цуглуулах /машин-1/	520	160	2640	422400
2	2-р баг сүүний дээж цуглуулах /машин-1/	860	230	2640	607200
3	3-р баг сүүний дээж цуглуулах /машин-1/	600	130	2640	343200
4	4-р баг сүүний дээж цуглуулах /машин-1/	120	60	2640	158400
5	5-р баг сүүний дээж цуглуулах /машин-1/	120	60	2640	158400
6	6-р баг сүүний дээж цуглуулах	320	100	2640	132000
7	Мотоциколь	1780	80	2620	209600
8	Мотор ажиллуулах		20	2620	52400
9	Хяналтаар явах/машин-1, нэг удаа/	900	180	2640	475200
Бүгд:		5220	1020	2640	2560800

Хүнсний зардал

№	Зардлын нэр төрөл	Хэмжээ	Шаардлагатай тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хонь	ш	2	150000	300000
2	Төмс	кг	15	2500	37500
3	Лууван	кг	7	2000	14000
4	Байцаа	кг	5	2500	12500
5	Сонгино	кг	5	3000	15000
6	Манжин	кг	3	2000	6000
7	Гурил	кг	10	1400	14000
8	Будаа	кг	15	3000	45000
9	Гоймон	кг	5	3600	18000
10	Бусад				72200
Бүгд:					534200